



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 08 өдөр

Дугаар А/158

Мандалговь

Газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай

Монгол Улсын Газрын тухай хуулийн 38 дугаар зүйл 38.1, 38.2, 38.4 дэх заалтууд, аймгийн ИТХ-ын 2018 оны 10 дугаар сарын 04-ны өдрийн тогтоол, газар эзэмших эрхийг шилжүүлэн авах төрийн байгууллагын хүсэлтийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

Нэг. Сайнцагаан сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэр (Г.Чагдаржавын гудамж-1-100тоот)-т байршилтай Мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төв (РД:9033866)-ийн боловсролын байгууллагын зориулалттай 8383 м.кв (0,8 га) газраас Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газар (РД:9033556)-т төрийн үйлчилгээний зориулалтаар 4434 м.кв (0,4 га), мөн Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газар (РД:9033556)-т төрийн үйлчилгээний зориулалтаар 553 м.кв (0,05 га), үлдсэн 3396 м.кв (0,3 га) газрыг боловсролын байгууллагын зориулалтаар Мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төв (РД:9033866)-д шилжүүлж 30 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

Хоёр. Дээрх хоёр байгууллагуудтай газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), мөн гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт, Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч (Р.Мөнхтогтох), аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат) нарт үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2005 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 157 дугаар захирамжийн Мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төвийн (8383м<sup>2</sup>) газарт холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

482010447